



## НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИСС

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж 13, 15140-0036  
Утас/Факс: (976-11) 31-83-92  
E-mail: nok@ulaanbaatar.mn  
http://www.nobg.ub.gov.mn

2022. 01. 13 № 14

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

Улсын онцгой комиссын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр хурлын тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хурлын тэмдэглэлийн 1.3 дахь заалтын хүрээнд Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтаас сэргийлэх, ажилтан, албан хаагчдаа цахимаар болон зайнаас ажиллуулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг зөвлөж байна.

Хавсралт 3 хуудастай.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
ХУРАНДАА



Д.ОЮУНБАТ



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

I ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 16.30 цагт Төрийн ордон дахь “Чингис хаан танхим”-д 81 хувийн ирцтэй хуралдуулав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ, төлөвлөгөө болон эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэлтийн талаар

Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд

2. Улсын онцгой комиссын 2021 оны үйл ажиллагааны товч тайлан

Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга,  
дэд хурандаа Т.Баярхүү

3. Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилсан сэргийлэх, тархалтыг бууруулахад зарцуулсан төсвийн талаар

Сангийн яамны,  
Төсвийн орлогын хэлтсийн дарга Б.Тэлмүүн

4. Бусад

## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

*Нэг. Улсын онцгой комиссын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр нарт:*

1.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын мутацिलाгдсан шинэ хувилбарын тархалтаас урьдчилан сэргийлэх, халдварын эсрэг дархлааны түвшинг нэмэгдүүлэх зорилгоор дархлаа сэргээх нэмэлт тунд идэвхитэй хамруулах ажлыг бүх шатанд зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

1.2. Коронавируст халдвар /Ковид-19/, томуу, томуу төст өвчний тархалт, эмнэлгийн ачаалал нэмэгдэх эрсдэлийг бодитоор тооцоолж бэлтгэл, бэлэн байдлыг бүх шатанд хангаж, эрчимжүүлэх, цар тахлын эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийж, 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабт мэдээллийг ирүүлэх;

1.3. Ажлын байр, албан байгууллагуудад Коронавируст халдвар /Ковид-19/ тархах, хүний нөөцийн дутагдалд орохоос урьдчилан сэргийлж, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх /цахимаар болон зайнаас ажиллуулах, ээлжийн хуваарьт оруулах, эрсдэлт бүлгийг халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах гэх мэт/;

*Хоёр. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дарга Б.Цэцэгсайхан нарт:*

2.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын мутацिलाгдсан шинэ хувилбар /В.1.1.529/-ын талаарх судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн орны нөөцөд тодотгол хийж, нөөцийг нэн даруй бүрдүүлж, татан авах, Улсын онцгой комисс, Засгийн газрыг үнэн бодит мэдээ, мэдээллээр хангаж, шуурхай ажиллах;

*Гурав. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дарга Б.Цэцэгсайхан нарт:*

3.1. Зах зээлд нийлүүлэгдэж байгаа амны хаалтны чанар, стандарт, эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч, үр дүнг 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Улсын онцгой комисст танилцуулах;

*Дөрөв. Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Т.Ганзулд:*

4.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын “Омикрон” хувилбарын эмнэлзүйн шинж тэмдэг, вакцины үр нөлөө, халдвараас урьдчилан сэргийлэх арга, хэлбэр гэх мэт шаардлагатай мэдээ, мэдээллийг Эрүүл мэндийн яам болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран тогтмол бэлтгэж, боломжит бүх сувгаар түгээх;

*Тав. Улсын онцгой комиссын гишүүн, Сангийн сайд, Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян нарт:*

5.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэгдсэн лавлах 119 дугаарыг ажиллуулах болон Коронавируст халдвар /Ковид-19/-ын шинжилгээний хариу хүргэхтэй холбогдон гарсан зардлын тооцоог гаргаж, Засгийн газрын нөөц сангаас холбогдох хууль, журмын дагуу гаргуулах;

5.2. Коронавируст халдвар /Ковид-19/-ын тандалт, шинжилгээнд ашиглаж буй программ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэгдсэн лавлах 119 дугаарыг ажиллуулах асуудлаар аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан гэрээг сунгах эсэх асуудлаар нэгдсэн санал боловсруулж, 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн дотор Улсын онцгой комисст танилцуулж, шийдвэрлүүлэх;

*Зургаа. Улсын онцгой комиссын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян нарт:*

6.1. Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дарга, Онцгой байдлын ерөнхий газар, Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабын удирдлагуудыг холбогдох хууль, журамд заасан хүрээнд шалгаж, хариуцлага тооцох асуудлыг шийдвэрлүүлэх;

*Долоо. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн хошууч генерал Ж.Болд, Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр нарт:*

7.1. 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн гадаад улсаас ирсэн бүх хүнийг тусгаарлан ажиглах байранд 3 хоног тусгаарлаж байгааг 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн зогсоох;

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Нэгдсэн шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр нарт даалгах.

ДАРГА

САМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ДЭД ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ

